| | | | | | | автотээврийн хэрэгслийн дугаарыг тухай бүр солих ажил хангалтгүй байсан тул дээрх ажлыг эрчимжүүлэх шаардлагатайг, мөн орон нутгийн өмчид бүртгэлтэй автотээврийн хэрэгслийн улсын дугаарын дэвсгэр энгийг тод хөх дэвсгэрээр солих ажлын явц муу байгаа учир цаашид эрчимжүүлэн зохион байгуулж ажиллахыг тус тус зөвлөсөн.<br>4. Тооллогын дүнгээр илэрсэн илүүдэлтэй, ашиглалтгүй хөрөнгийг худалдах, актлаж данснаас хасах, шилжүүлэх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж ажиллахыг, улсын орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, гадаад, дотоодын хандив, тусламж, бэлэглэл, орон нутаг болон сум хөгжүүлэх сан, төсөл хөтөлбөрийн арга хэмжээ, түүхт ойн арга хэмжээний хүрээнд шинээр бий болсон хөрөнгүүдийг санхүүгийн тайлан балансад бүртгэх ажлын явцтай танилцаж, цаашид хэрэгжилтийг тогтмол хангаж ажиллах шаардлагатайг зөвлөсөн.<br>5. "Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам батлах тухай" 2022 оны 65 дугаар тогтоолын хүрээнд байгууллагуудын өмч хамгаалах зөвлөлийн ажлын явц, хэрэгжилттэй танилцаж, барилга байгууламжийн хувийн хэрэг, тээврийн хэрэслийн хувийн хэргийн бүрдүүлэлт, хөтлөлттэй танилцахад зарим байгууллага хувийн хэргийг шинэчлээгүй, бичилт дутуу хийгдсэн зэрэг зөрчил илэрсэн. Иймд илэрсэн зөрчил, дутагдлыг арилгаж, цаашид зөрчилгүй ажиллахыг үүрэг болгосон.<br>6. Аймгийн ИТХ-ын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллах, өмч хувьчлалын орлогын төвлөрүүлэлтийг хянаж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүрэг болгосон.<br>7. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 49 дүгээр, 50 дугаар тогтоолын хүрээнд түрээслэсэн эд хөрөнгийн байршил зүй, жагсаалт /түрээсийн гэрээ, түрээсийн төлбөр/-ыг гаргуулан авсан.<br>8. Аймгийн Засаг даргын 2024 оны А/164 дүгээр захирамжаар батлагдсан "Өмч эзэмшүүлэх гэрээ"-ний хэрэгжилтийг дүгнэн баталгаажуулж ажилласан. | |
| Зорилт 2. "Өмчийн харилцаанд дагаж мөрдөгдөх холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтийг хангаж, хяналт тавих, захиргааны эрх зүйн үндэслэлийг хянаж, шүүхийн байгууллагад төлөөлж, албан хаагчдын үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, дотоод аудит, ил тод байдлыг хангуулан эрсдэлээс урьдчилан сэргийлэх" | | | | | | | |
| 2.1 | Орон нутгийн өмчийн харилцааны талаар баталж буй захиргааны акт, гэрээ, дүрэм, журам, зааврын хууль, эрх зүйн үндэслэлийг хянаж хэрэгжилтийг хангах; | Орон нутгийн төсөв | Хэрэгжилтийн хувиар | 80% | 100% | Аймгийн Засаг даргын 2024 оны 03 сарын 07-ны өдрийн А/164 дүгээр захирамж болон өмч эзэмшлийн гэрээний маягт батлах, гэрээг дүгнэх аргачлалын хууль эрх зүйн үндэслэлийг холбогдох хууль тогтоомжтой тулгалт хийж, хянаж шийдвэрийг гаргуулсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.2 | Байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, гэмт хэрэг зөрчлөөс сэргийлэх, авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, ХАСХОМ-ийг хуульд заасан хугацаанд тайлагнан хүргүүлэх; | Орон нутгийн төсөв | Биелэлтийг хуулийн хугацаанд тайлагнасан хувиар | 100% | 100% | Орон нутгийн өмчийн газрын дарга, Нягтлан бодогч нийт 2 албан тушаалтан ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд гаргаж, аймгийн ЗДТГ-ын Хууль эрхзүйн хэлтэст хүргүүлэн, баталгаажуулсан. | 100 |
| 2.3. | Тухайн жилд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөөг боловсруулах, батлуулах төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах; | Орон нутгийн төсөв | Төлөвлөгөө-ний хэрэгжилтийн хувиар | 30% | 100% | 2024 оны хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөөг батлуулж, төлөвлөгөөний дагуу tov.unelgee.gov.mn цахим системийн хэрэгжилтийг цаг хугацаанд нь хүргүүлэхэд хяналт тавих зорилгоор албан хаагчдаас урьдчилсан байдлаар хэрэгжилтийн тайланг авч, мэдээллийн санг бүрдүүлэв. Мөн Аймгийн Засаг даргын 2024 оны А/164 дугээр захирамжаар газрын даргын батлагдсан удирдамжийн дагуу "Өмч эзэмшлийн гэрээг дүгнэх" ажлын хэсэгтэй хамт 2024 оны 09 сараас эхлэн 200 байгууллагад хяналт тавьж ажиллав. | 70 |
| 2.4. | Байгууллагын үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүнгийн талаарх сэтгэл ханамжийн судалгааг авч дүнг нэгтгэн үр дүнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, хэрэгжилтийг хангах; | Орон нутгийн төсөв | Гүйцэтгэлийн чанар (хувиар) | 40% | 100% | Хагас жилээр төрийн захиргааны 5, төрийн үйлчилгээний 9, нийт 14 албан тушаалтнаас сэтгэл ханамжийн судалгааг авсан бөгөөд тус судалгааг нэгтгэн албан хаагчдаас ирсэн саналыг харгалзан үзэж зохиох арга хэмжээг авч ажиллахаас гадна судалгааны нэгтгэлийн үр дүнд хангалтгүй ажил болон, дутагдалтай ажиллаж байгаа албан хаагчдад зохих шаардлагыг тавьж өдөр тутмын үйл ажиллагаанд нь хяналт тавин алдаа дутагдлыг арилгуулан ажиллав. | 100 |
| 2.5. | Тухайн жилд дотоод аудит, дотоод хяналт хийх чиглэлийг тодорхойлж, төлөвлөгөө боловсруулан батлуулан хэрэгжилтийг хангах; | Орон нутгийн төсөв | Төлөвлөгөө-ний хэрэгжилтийн хувиар | 90% | 100% | Байгууллагын даргын 2024 оны А/08 дугаар тушаалаар Дотоод хяналт шалгалтын зөвлөлийг шинэчлэн байгуулж, дарга, гишүүдийг томилж, хавсралтаар журмыг батлав. Журамтай уялдуулж 2024 оны дотоод хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөг боловсруулан, төлөвлөгөөний дагуу удирдамж боловсруулан хагас, бүтэн жилээр дотоод хяналт шалгалтыг зохион байгуулж, хэрэгжилтийг тайланг гарган удирдлагад танилцуулна ажиллав. | 100 |
| 2.6. | Дотоод хяналтын үр дүнгээр гарсан зөрчил, дутагдлын талаар цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал, | Орон нутгийн төсөв | Хэрэгжилтийн хувиар | 40% | 100% | Эхний хагас жилээр дотоод хяналт шалгалтын хүрээнд удирдамж боловсруулан даргаар батлуулж, шалгалтын явцад илэрсэн няравын санхүүгийн анхан шатны бүртгэл хөтлөлт, баримт бичиг хангалтгүй байсан гэх зөрчлийг арилгуулахаар хугацаатай үүрэг даалгавар өгч, хяналт тавьж ажилласан бол | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | зөвлөмж боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавих; | | | | | жилийн эцсийн байдлаар байгууллагын тооллогын комиссын эд хөрөнгө, хөрөнгийн ашиглалт, хамгаалалтад хийгдсэн ажилд хяналт тавьж, байгууллагад ирсэн, явсан бичиг, хариутай бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн талаар хяналт тавихад гарсан зөрчилгүй. | |
| 2.7. | Хяналт шалгалт хийсэн Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд газар эзэмших, ашиглах эрхийн байдалд дүн шинжилгээ хийх; | Орон нутгийн төсөв | Хамрагдсан хуулийн этгээдийн тоо | - | 5 | Хяналт шалгалтын батлагдсан удирдамжийн дагуу сумдад ажиллахдаа орон нутгийн өмчит хуулийн этгээдийн газрын эзэмших, ашиглах эрхийг баталгаажуулах, цахим бүртгэлд бүрэн хамруулах, үнэлээгүй газрыг үнэлж санхүүгийн тайланд тусгах ажлыг эрчимжүүлж ажилласан.<br>Цаашид газрын маргаан, зөрчил гарвал зөрчлийг арилгах арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг хуулийн этгээдийн дарга, нягтлан бодогч нарт үүрэг болгосон. | 100 |
| 2.8. | Баримтын шалгалтад хамрагдсан хуулийн этгээдийн Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих; | Орон нутгийн төсөв | Хяналт тавих хуулийн этгээдийн тоо | - | 5 | Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дарга (захирал, эрхлэгч) нарт Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг зөвлөж, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан. | 100 |
| Зорилт 3. "Хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, албан хаагчдын нийгмийн баталгаа, сургалт, хөгжлийн асуудлаар хөтөлбөр, төлөвлөгөө, санал, төсөл боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах, үр дүнг тайлагнах | | | | | | | |
| 3.1.1. | Төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллах; | Орон нутгийн төсөв | Хэрэгжилтийн хувиар | 92% | 100% | <u>Төлөвлөгөөнд тусгагдсан албан хаагчийг мэргэшүүлэх чадавхижуулах, давтан сургах ажлыг зохион байгуулах хүрээнд:</u><br>-Удирдлагын академиас зохион байгуулсан "Монгол улсын хөгжлийн бодлого, хэрэгжилт: үр дүнд суурилсан төлөвлөлт, гүйцэтгэл" сэдэвт цахим, танхим хосолсон богино хугацааны (16 цаг) сургалтад 1 албан хаагч,<br>-Төрийн албаны зөвлөлөөс 7 хоног бүрийн Пүрэв гарагт зохион байгуулдаг 7:4:10 цахим 23 удаагийн сургалтад 8 албан хаагч,<br>-Төрийн албан хаагчийн "Ёс зүйн тухай" хуулийн сургалт,<br>-Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилт, төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд үнэлгээ хийх арга хэлбэрийг өөрчлөх, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, үр дүнд суурилсан үнэлгээ мониторингийн тогтолцоог хөгжүүлэхээр шинэчлэн найруулсан журмын төслийг танилцуулах нэгдсэн сургалт, хэлэлцүүлэгт байгууллагын удирдлага, төрийн захиргааны 4 албан хаагч, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | -Төрийн болон орон нутгийн өмчийн харилцааны салбарын нэгдсэн сургалт, зөвлөгөөнд төрийн захиргааны 6 албан хаагч,<br><br>-"Монголын хөрөнгийн бирж" ХК Монгол Улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газартай хамтран зохион байгуулсан "Төрийн болон орон нутгийн өмчит компанийн шинэчлэл ба хөрөнгийн зах зээл" 2 өдрийн сургалт, хэлэлцүүлгийн нэгдсэн арга хэмжээнд газрын дарга, ахлах мэргэжилтнүүд нийт 4 албан хаагч тус тус хамрагдсан.<br><br><u>Аймгийн ЗДТГ, холбогдох агентлагаас зохион байгуулсан сургалт:</u><br>-Агентлаг, байгууллагын Жендэрийн асуудал хариуцсан орон тооны бус мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалтад 1 албан хаагч,<br>-Аймгийн Эрүүл мэндийн газраас зохион байгуулсан "Бэлгийн замаар дамжих халдварын өнөөгийн байдал" сэдэвт сургалтад байгууллагын Залуучуудын зөвлөлийн 2 албан хаагч,<br>-"Хүүхэд хамгааллын тухай" хууль (шинэчилсэн найруулга), Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, "Хосоо ойлгоё" гэр бүлийн боловсрол олгох сургалтад нийт албан хаагчид,<br>-Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газраас зохион байгуулсан "Өсвөр насны хүүхдийн нас сэтгэлзүйн онцлог эцэг, эхийн хамаарал" сэдэвт сургалтад байгууллагын дэргэдэх Эцэг, эхийн зөвлөлийн 1 албан хаагч,<br>-Нийгмийн даатгалын багц хууль, нийгмийн даатгалын мэдээллийн шинэчлэлтэй холбогдуулан аймгийн Нийгмийн даатгалын газраас зохион байгуулж буй сургалтад албан хаагчдаа тус тус хамруулж, төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийг бүрэн ханган ажиллаа.<br>холбогдох чиглэлээр<br>-"Шинэ ажилтныг туршилтын хугацаанд чиглүүлэх хөтөлбөр"-ийн хүрээнд төрийн захиргааны 3 албан хаагчийг шавилан сургаж, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх ажлыг зохион байгууллаа. | |
| 3.1.2. | Мэргэшүүлэх багц сургалт (танхимын болон зайн, урт болон богино хугацааны)-д болзол шаардлага | Орон нутгийн төсөв | Багц сургалтад хамрагдсан ТАХ-ын тоо | 2 | 3 | Төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалтын агуулга, хөтөлбөрийн хүрээнд Удирдлагын академийн мэргэшүүлэх дунд шатны багц сургалт, дунд шатны давтан сургалтад болзол шаардлага хангасан төрийн захиргааны 3 албан хаагч хамрагдаж байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хангасан төрийн албан хаагчдыг хамруулах; | | | | | | |
| 3.1.3. | "Шинэ ажилтныг туршилтын хугацаанд чиглүүлэх хөтөлбөр"-ийн хүрээнд дадлагажуулах зорилгоор шавилан сургах; | Орон нутгийн төсөв | Хамрагдалтын хувиар | Нягтлан бодогч, Дотоод ажил, архив, албан хэрэг хөтөлтийн хариуцсан ажилтан нарыг шавилан сургасан 100 хувь | 100 хувь | ТАЗ-ийн Төв аймаг дахь салбар зөвлөлийн 2024 оны 18 дугаар тогтоолоор Төрийн захиргааны гүйцэтгэх албан тушаалд томилогдсон 2, Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах зохицуулалтаар томилогдсон 1, нийт 3 шинэ албан хаагчийг албан тушаалын тодорхойлолт, ажлын чиг үүргийн дагуу шинэ ажилд дадлагажуулан сургаж, төрийн албаны сахилга хариуцлага, мэдлэг чадвар, ёс зүй харилцаа хандлага, ур чадварыг эзэмшүүлэн ажиллаа. | 100 |
| 3.1.4. | Ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, хамгаалах чиглэлээр тодорхой заалтуудыг байгууллагын Хөдөлмөрийн дотоод журамд тусгаж, түүнтэй холбоотой гомдлын шийдвэрлэлтэд хяналт тавих; | Орон нутгийн төсөв | Гомдлын тоо, хувиар | 2023 онд гомдол гараагүй 0 | 100% | Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн боловсруулж, журмын 10.2.9-д "Ажил олгогч хөдөлмөрийн харилцаанд жендерийн ялгаварлан гадуурхалт үүсгэхгүй байх, ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх нөлөөллийн болон бэлгийн дарамтыг үл тэвчих орчин бүрдүүлж ажиллана" гэсэн заалт оруулж, газрын даргын 2024 оны А/12 дугаар тушаалаар баталсан. Тушаалын хэрэгжилтэд байгууллагын дэргэдэх "Ёс зүйн дэд хороо" хяналт тавьж ажиллахад дээрх заалттай холбоотой санал гомдол гараагүй хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллаа. | 100 |
| 3.1.5. | Байгууллагын Гамшгаас хамгаалах төлөвлөгөө"-г шинэчилэн боловсруулан тодотгож, ажил үүрэг, ажлын цагийн зохицуулалтад хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулах; | Орон нутгийн төсөв | Зарцуулсан хөрөнгийн дүн (хувиар) | 1,500.000 төгрөг зарцуулсан | 100% | Байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөөг шинээр гарсан хууль тогтоомж, дүрэм заавартай уялдуулан шинэчилэн боловсруулж, мэргэжлийн байгууллагаар баталгаажуулахаар хүргүүлсэн. | 90 |
| 3.2 Төрийн албан хаагчийн тогтвортой ажиллах нөхцөлийг бэхжүүлж, нийгмийн асуудлыг шат дараатай шийдвэрлэх | | | | | | | |
| 3.2.1 | Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах; | Орон нутгийн төсөв | Гүйцэтгэлийн хувиар | 92% | 100 % | Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн боловсруулж, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах талаар хууль тогтоомжийн хүрээнд нэмэлт өөрчлөлт оруулсан.<br>-Төр захиргааны 2 дугаар байранд үйл ажиллагаа явуулдаг Төрийн Аудитын газар, Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба, Худалдан авах ажиллагааны газар, БЗОСК ОНӨААТҮГ, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Төрийн архивын тасаг нийт 6 байгууллагаас үйлчилгээ авах иргэдийг ая тухтай орчинд үйлчлүүлэх, албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хүрээнд 1, 2 дугаар давхар, гадна, дотор орчныг сайжруулахад 902,110 төгрөгийн засвар үйлчилгээ хийсэн. Аймгийн 2024 оны төсвийн тодотголоор Төр захиргааны 2 дугаар байрны дулаан сантехникийн шугам сүлжээний их засварт 324,743,517 төгрөгийн санхүүжилт хуваарьлагдан, тендерт "Тантра Энержи" ХХК шалгарч уг байранд үйл ажиллагаа явуулдаг 6 байгууллагын албан хаагчдын ажиллах орчныг сайжруулсан.<br><br>-Албан хаагчдыг ажиллах нөхцөл, шаардлагатай техник хэрэгслээр хангаж ажиллах хүрээнд: Тайлант оны эхний хагас жилд 15,0 сая төгрөгөөр 4 ширхэг компьютер, төсвийн тодотголоор багаж, техник хэрэгслийн зардалд 20,0 сая төгрөгийн санхүүжилт хуваарьлагдаж, 7 ширээ, 10 сандал, бичиг хэргийн төмөр шкаф 6, өнгөт принтер 1, цахилгаан тэнь 1 ширхэгийг шууд гэрээгээр тус тус худалдан авч, 8 албан хаагчийг шаардлагатай техник хэрэгслээр хангаж ажиллаа.<br><br>Төрийн захиргааны албан хаагчдад зэрэг дэв, нийт албан хаагчдад төрийн алба хаасан хугацааны, орон нутгат ажилласны нэмэгдэл, үр дүнгийн урамшуулал, хоол унааны хөнгөлөлт, албан томилолтоор ажиллах үеийн нөхөх олговорыг бүрэн олгосон. | |
| 3.2.2 | Төрийн албан хаагчийг эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд бүрэн хамруулах; | Өөрийн нөөцөөр | Хамрагдсан төрийн албан хаагчийн тоо | 2022-2023 онд ТАХ-14 | 3 | Байгууллагын 6 албан хаагчид өөрийн зардлаар нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамрагдаж, эрүүл аж төрөх, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх зөвлөгөө авсан. Эрт илрүүлэлтийн урьдчилан сэргийлэх үзлэгт албан хаагчдыг хамруулах ажил төсвийн жилийн санхүүжилтээс шалтгаалж хойшилсон. Албан хаагчид нь суугаа ажил эрхэлдгээс үүдэн нуруун суулт, хүзүүний шохойжилт, хуян хөөрөх зэрэг олдмол өвчинд өртөж байгаа тул байгууллагын зүгээс албан хаагчдын эрүүл мэндийг баталгаар хангаж нүд, хүзүүний аппарат авч ажиллуулж байна. Үүний үр дүнд халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ болсон. | 70 |
| 3.2.3 | Төрийн албан хаагчдыг төрийн дээд, салбарын болон бусад шагналд нэр | Өөрийн нөөцөөр | Шагнагдсан төрийн албан хаагчийн тоо | Төв аймаг байгууллагдса ны түүхт 100 жилийн ойн | 5 | 2024 онд 4 албан хаагчийг салбарын болон аймаг, сумын шагналд тодорхойлж, 1 албан хаагч Зуунмод сумын "ХӨДӨЛМӨРИЙН АВАРГА" Төрийн захиргааны албан хаагч номинацид, 1 албан хаагч аймгийн "Хүндэт тэмдэг"-ээр, ТӨБЗГ- | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | дэвшүүлж, шагнаж урамшуулах; | | | хүрээнд нийт 4 албан хаагч шагнагдсан. | | ын "Жуух бичиг"-ээр 2 албан хаагч тус тус шагнагдсан. Ардын хувьсгалын түүхт ой, Аймгийн түүхт 101 жилийн ойг тохиолдуулан төрийн дээд одон медаль Алтангадас одон, Хөдөлмөрийн Хүндэт медальд нийт 7 албан хаагчийг тодорхойлж, аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-т хүргүүлсэн. | |
| 3.2.4. | Төрийн албан хаагчийн тэтгэмж, урамшуулал, үндсэн болон нэмэгдэл цалин хөлс, бусад зардал, сургалт, хөгжлийн асуудалтай холбоотой зардлын тооцоо, төсвийг тухайн жилийн төсвийн төсөлд тусгах санал боловсруулах, хууль тогтоомжийн болзол, шаардлага хангасан төрийн жинхэнэ албан хаагчдад зэрэг дэв олгуулах ажлыг зохион байгуулах; | Орон нутгийн төсөв | Зарцуулах хөрөнгийн хувиар | 2023 онд албан хаагчдад зэрэг дэв, төрийн албан хаасан хугацааны, үр дүнгийн урамшуулал, үр чадварын нэмэгдэл, хоол унааны хөнгөлөлт, ажиллах орчныг сайжруула-хад нийт 34,352,214 төгрөгийг зарцуулсан байна. | 100% | Төрийн албан хаагчийн тэтгэмж, урамшуулал, үндсэн болон нэмэгдэл цалин хөлс, бусад зардал, сургалт, хөгжлийн асуудалтай холбоотой зардлын тооцоо, төсвийг 2025 оны төсвийн төсөлд тусгах санал боловсруулан аймгийн ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтэст хүргүүлж, батлуулсан. Аймгийн Засаг даргын 2024 оны Б/03 дугаар захирамжийн хүрээнд ОНӨГ-ын даргын Б/18 дугаар тушаалаар 1 албан хаагчийн зэрэг дэвийг нэмэгдүүлж, нийт албан хаагчид төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэлд 14,343,722.25 төгрөгийг бүрэн олгосон. | -90- 100% |
| 3.3. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр | | | | | | | |
| 4.1. | Жендэрийн дэд салбар зөвлөл байгуулах, Жендэрийн дэд салбар зөвлөлийн 2024 оны арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан, батлуулж, хэрэгжүүлэх; | Орон нутгийн төсөв | Дэд салбар зөвлөл байгуулсанаар Төлөвлөгөө-ний хэрэгжилтийн хувь | 80% | 90% | Жендэрийн эрх тэгш байдлын тухай хууль, аймгийн хэмжээнд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөө (2023-2026), Жендэрийн салбар хорооны 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, аймгийн Засаг даргын 2024 оны 01/173 дугаар албан бичиг "Зөвлөмж хүргүүлэх тухай"-ийн хэрэгжилтийг хангах хүрээнд "Жендэрийн дэд салбар зөвлөл"-ийг ОНӨГ-ын даргын 2024 оны А/05 дугаар тушаалаар томилж, "Жендэрийн дэд салбар зөвлөлийн ажиллах журам", 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан батлуулсан. Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аяныг үндэсний хэмжээнд "Охид, эмэгтэйчүүд хаана ч аюулгүй- Шалтаг бүү тооч" уриа дэвшүүлэн эхлүүлсэн. Тус аяны хүрээнд байгууллагын албан хаагчдад "Жендэрийн талаарх үндсэн | -90 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ойлголт" сэдэвт сургалт зохион байгуулж, байгууллагын цахим хаягт Жендэрийн Үндэсний хороо, аймгийн Жендэрийн салбар хорооны пэйж хуудсанд нэгдэж, аяны хүрээнд хийгдэж буй цахим постер, уриа баннер, шторкуудыг олон нийтэд түгээн дэлгэрүүлэх ажил хийгдэж, хэрэгжилтийг ханган ажиллаа. | |
| 4.2. | Хүний эрх, жендерийн боловсрол олгох ажлын хүрээнд төрийн албан хаагчийг Жендэрийн анхан болон ахисан түвшний сургалтад (сертификаттай) хамруулах; | Орон нутгийн төсөв | Сертификат авсан ажилтаны тоо | 3 | 4 | Жендэрийн анхан болон ахисан түвшний сургалтад 9 албан хаагч хамрагдаж, сертификат авч, хүний эрх, жендэрийн талаарх мэдлэгээ дээшлүүлсэн. | ~~90~~ 100% |
| 4.3 | Стратеги төлөвлөгөөг хяналтад авч, холбогдох заалтын хэрэгжилтийг хагас жилээр 06 дугаар сарын 21, жилийн эцсээр 11 дүгээр сарын 29-ний дотор Нийгмийн бодлогын хэлтэст тайлагнах; | Орон нутгийн төсөв | Хэрэгжилтийн хувь | 90% | 90% | Стратеги төлөвлөгөөний холбогдох заалтын хэрэгжилтийг эхний хагас жил, жилийн эцсийн байдлаар гаргаж, аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэст хүргүүлсэн. | 90 |
| Зорилт 4 "Төсвийг төлөвлөж, батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу хуваарилах, хяналт тавих, үр ашигтай зарцуулж, гүйцэтгэлийг тайлагнах" | | | | | | | |
| 4.1. | 2024 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарьт оруулан батлуулах; | Орон нутгийн төсөв | Хэрэгжилтийн хувиар | 100% | 100% | 2024 оны батлагдсан 586,661.4 төгрөгийн төсвийн сарын хуваарийг батлуулж, эрхийг сар бүр нээлгэн төсвийн шууд захирагчийн зөвшөөрлөөр зарцуулан ажиллаж байна. | 100 |
| 4.2. | Төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүрээр, санхүүгийн тайланг улирал, хагас, бүтэн жилээр бэлтгэж, тайлагнах; | Орон нутгийн төсөв | Хэрэгжилтийн хувиар | 100% | 100% | Төсвийн гүйцэтгэлийн сарын тайлан, мэдээг гарган аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэст нэгтгүүлэн, 11 дүгээр сарын байдлаар 542,706.2 төгрөгийн гүйцэтгэлээр хуваарийн дагуу төсвийн шууд захирагчийн зөвшөөрлөөр зарцуулан ажиллаа. Санхүүгийн тайланг эхний хагас жилийн байдлаар гаргаж, хугацаанд нь тайлагнасан. | 100 |
| 4.3. | 2025 оны төсвийн хүрээний мэдэгдлийг хуулийн хугацаанд төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны | Орон нутгийн төсөв | Төлөвлөгөөний гүйцэтгэлийн хувиар | 100% | 100% | Сангийн яамнаас ирүүлсэн удирдамжийн дагуу 2025 оны төсвийн төсөл 2026, 2027 оны төсвийн төсөөллийг бэлтгэн 2024 оны 07 дугаар сарын 08-ны өдөр аймгийн ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтэст хүргүүлэн нэгтгүүлсэн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байгууллагад холбогдох тооцоо судалгааг хийж нэгтгүүлэх; | | | | | | |
| Зорилт 5 "Үндэсний Монгол хэл, бичгээ чанартай эзэмшиж, хэрэглэж хэвших" | | | | | | | |
| 5.1. | "Өв соёлоо эрхэмлэж, үндэсний бичгээ сурцгаая-2025" аян өрнүүлэн, төрийн албан хаагчдын монгол хэл, бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлж, төрийн албан хэрэг хөтлөлтийг хос бичгээр хөтлөх ажлыг зохион байгуулах; | Орон нутгийн төсөв | Хамрагдалтын хувиар | 2023 онд 7 ТАХ | 100% | -"Монгол бичгээр үйлдэх баримт бичгийн хэвлэмэл хуудас, түүний бүрдэлд тавих үндсэн шаардлага" MNS 6395:2022 стандартын дагуу албан хэргээ кирилл болон үндэсний хос бичгээр хөтлөн турших ажлын хүрээнд байгууллагын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд хэрэглэдэг монгол бичгээр үйлдэх тушаал, албан бичиг А4, А5 хэвлэмэл хуудсыг тус бүр 100 ширхэг, нийт 300 ширхэгийг захиалж стандартын дагуу хэвлүүлэн, тушаал 2, албан бичиг 6 тус тус гаргаж туршилтын ажлыг эхлүүлсэн.<br>-Удирдлагын Академийн монгол хэлний анхан шатны сургалтад 2 албан хаагч амжилттай хамрагдаж гэрчилгээ авсан. Дотоод ажил, хүний нөөц, архив, бичиг хэргийн ажилтан Насан туршийн суралцахуйн төвийн Гэрээт багшаас танхимын сургалтад хамрагдаж, ур чадвараа дээшлүүлж байна. Аймгийн Хэлний бодлогын салбар зөвлөлөөс зохион байгуулсан "МОНГОЛ БИЧИГТЭН-ТӨРИЙН АЛБАН ХААГЧ" уралдаанд 1 албан хаагч амжилттай оролцсон.<br>-Байгууллагын хэмжээнд монгол бичгээ сурах өдөр, Эх хэлний өдрийг Орон нутгийн өмчийн газрын даргын 2024 оны А/20 дугаар тушаалаар баталсан.<br>-Монгол бичгийн буланг нээж байгууллагын албан хаагч, иргэд олон нийтэд монгол бичгийн хэрэглээний орчинг бүрдүүлсэн.<br>-"Монгол хэлний компьютерийн орчны тогтолцоо Тооцоолох хэрэгслийн гарын товчлуур дээрх монгол бичгийн үсэг, тэмдэгтийн байршил" "MNS 7004:2023" стандартын хүрээнд албан хаагчдын компьютерийн гарын товчлуур дээр Mongolian baiti фонт суулгаж, албан хэргийг хос бичгээр хөтлөн явуулах ур чадварыг эзэмшүүлэх ажил явагдаж байна. | 90 |
| "ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | | |
| Зорилт 1: "Залуучуудын манлайлал-гэр бүлийг дэмжих жил"-ийн хүрээнд | | | | | | | |
| 1.1. | Урианы жилийн хүрээнд залуу албан хаагчдад "Амьдрах ухааны болон санхүүгийн мэдлэг чадвар эзэмших" сургалт зохион байгуулах; | Орон нутгийн төсөв | Хамрагдалтын хувиар | 2023 онд 1 удаа 50% | 100% | Амьдрах ухаан сургалтын байгууллагаас "Өөрийгөө таниж мэдэх ба өөрийгөө тодорхойлох нь" сэдэвт сургалтад 15 албан хаагч хамрагдав. Мөн залуу албан хаагчдыг чадавхжуулах зорилгоор "Залуучуудын оролцоо-орон нутгийн хөгжилд" сэдэвт төслийн сургалтад 2 албан хаагч хамрагдсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.2. | Эх орончуз үзлийг эрхэмлэж, ёс заншил, өв уламжлалаа дээдлэх талаар уулзалт зохион байгуулах; | Орон нутгийн төсөв | Хамрагдалтын хувиар | 2023 онд 1 удаа 50% | 100% | 2024 оны 03 дугаар сарын 01-ний "Эх орончдын өдөр"-ийг тохиолдуулан байгууллагынхаа хүрээнд уулзалт зохион байгуулж ажиллаа. | 100 |
| 1.3. | Эрүүл чийрэг, чадварлаг бүтээлч, бие бялдарыг хөгжүүлэхэд байгууллагаас дэмжлэг үзүүлж, спортын өдөрлөгийг зохион байгуулах; | Орон нутгийн төсөв | Хамрагдалтын хувиар | 2023 онд 1 удаа 50% | 100% | Албан хаагчид нь суугаа ажил эрхэлдгээс үүдэн нурууны суулт, хүзүүний шохойжилт, хуян хөөрөх зэрэг олдмол өвчинд өртөж байгаа тул байгууллагын зүгээс албан хаагчдын эрүүл мэндийн баталгаар хангаж нүд, хүзүүний аппарат авч ажиллуулж байна. Мөн урин дулааны улиралд 7 хоног бүрийн 3 дах өдөр болгон "Манзушир хийд" рүү 3 албан хаагч өглөөний алхалт хийж байсан бол өвлийн улирал ирсэнтэй холбогдуулан 3 албан хаагч спиннинг буюу дугуйн спортоор хичээллэж байгааг харгалзан үзэж, өглөө ажлын 9 цагаас хойш 30 минут цалинтай чөлөө олгож байна. | 100 |
| 1.4. | Төрийн албан хаагчдыг төрийн байгууллагад тогтвор суурьшилтай ажиллаж, амьдрах нөхцөлөө дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. | Орон нутгийн төсөв | Хэрэгжилтийн хувиар | - | 100% | 1.Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах үүднээс байгууллагын 1 албан хаагчид 2,825,523 төгрөгийн тоног төхөөрөмж, байгууллагын дотоод засварт 902,110 төгрөг, 5 жилийн тэтгэмжид 4 албан хаагч хамрагдаж 28,644,144 төгрөг, салбартаа ажлаар тэргүүлж шагнал авсан 3 албан хаагчид 200,000 төгрөг, улирлын мөнгөн урамшууллыг 15 албан хаагчид 5,403,850 төгрөгийг олгов.<br><br>2. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Түрээсийн орон сууцны сан бүрдүүлж, зорилтод бүлгийн иргэдийг түрээсийн орон сууцанд хамруулах журам"-ын дагуу өрх толгойлсон ээж тус байгууллагын нягтлан бодогчийг түрээсийн орон сууцад хамруулсан. Ингэснээр өөрийн гэсэн орон сууцтай боломжтой болсон. | 100 |
| Зорилт 2: Төрийн байгууллагын үйл ажиллагааг нээлттэй, ил тод, шуурхай хүргэх, олон нийтийн хяналтыг бий болгох ажлын хүрээнд | | | | | | | |
| 2.1. | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хүрээнд байгууллагын мэдээллийг тайлагнаж, хэрэгжилтийг хангаж ажиллах; | Орон нутгийн төсөв | Хэрэгжилтийн хувиар | 100% | 100% | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хүрээнд: Байгууллагын үйл ажиллагааны болон нээлттэй дуудлагын худалдааны мэдээ, мэдээллийг https://umch.to.gov.mn/ веб сайтаар, "Төв аймгийн Орон нутгийн өмчийн газар" фейсбүүк хуудсаар дамжуулан иргэд, олон нийтэд хүргэн ажиллаж байна. | 100<br>0% |
| 2.2. | Шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн оруулж, | Орон нутгийн төсөв | Хэрэгжилтийн хувиар | 100% | 100% | Шилэн дансанд 171 мэдээлэл байршуулахаас 2024 оны 11 дүгээр сарын байдлаар 152 мэдээллийг цаг хугацаанд нь үнэн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгжилтийг хангаж ажиллах; | | | | | зөв мэдээллэсэн. Хугацаа болоогүй буюу 12 дугаар сард мэдээллэх 19 мэдээлэл байна. | |

ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЯНАСАН: ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ
ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА .............................. Л.ТӨМӨРЧӨДӨР
(албан тушаал) (гарын үсэг)
2024.12.12
(огноо)
тэмдэг ..............................

ТӨЛӨВЛӨГӨӨ ТАЙЛАГНАСАН: ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГА .............................. Д.БАТЖАРГАЛ
(албан тушаал) (гарын үсэг)
2024.12.12
(огноо)
тэмдэг ..............................

ТУ34307 1424030016 3870235